



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 07 сарын 31 өдөр

Дугаар A/132

Улаанбаатар хот

### Арилжаанд оролцох эрх шилжүүлэн олгох тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” Хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11 дэх заалт, “Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.3.1 дэх заалт болон “Новел инвестмент ҮЦК” ХХК-ийн 2023 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн албан хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гишүүн “Новел инвестмент ҮЦК” ХХК-ийн ажилтан Э.Хуягбаатарын нэр дээрх NOVL.EKN нэртэй үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг тус компанийн брокер Н.Дэлгэрмөрөн -нд шилжүүлэн олгосугай.
2. Арилжаанд оролцох эрх авсан ажилтанд Монгол улсын үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, өндөр хариуцлага, ёс зүйтэй ажиллахыг үүрэг болгосугай.
3. Үнэт цаасны арилжааны программд нэвтрэх нэр, нууц үг олгох ажлыг Үйл ажиллагааны газрын Арилжааны алба /Д.Алдармаа/-нд, тушаалын биелэлтэд Хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-нд даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

1523030292